

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/65/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа
Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com
Аудитор: Ц.Оюунтуул
Утас: 99140953 Цахим хаяг: asaudit.zul@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт.....	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАХИРАЛ
М.АЛТЫНАЙ ТАНАА

2023.02.17 № 92
танай _____ -ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ байгууллагын онцлогт тохируулан батлах, хүнсний технологийн картыг баталж хэрэгжүүлэх

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,212,161.40</u>	<u>76,218,394.32</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	41,623,918.91
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	41,623,918.91
3121	Төгрөг	-	41,623,918.91
31211	Төрийн сангийн харилцах		41,623,918.91
35	БАРАА МАТЕРИАЛ	15,212,161.40	34,594,475.41
354	Хангамжийн материал	15,212,161.40	34,594,475.41
35420	Аж ахуйн материал	6,833,000.00	16,833,000.00
35440	Түлш, шатах тослох материал	502,650.41	717,200.41
35460	Хүнсний материал	3,581,685.99	6,705,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,294,825.00	10,339,275.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>187,992,852.21</u>	<u>215,889,046.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	187,992,852.21	215,889,046.94
392	Биет хөрөнгө	182,088,852.13	210,073,046.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	170,384,291.29	170,384,291.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,173,071.56)	(6,346,143.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,117,400.00	37,718,890.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,412,959.89)	(5,478,923.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,475,060.00	19,992,773.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,301,867.71)	(6,197,840.91)
393	Биет бус хөрөнгө	5,904,000.08	5,816,000.12
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(175,999.92)	(263,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,200,000.00	5,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>218,205,013.61</u>	<u>292,107,441.26</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>218,205,013.61</u>	<u>292,107,441.26</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,200,000.00	5,200,000.00
51101	Өмч: - төрийн	5,200,000.00	5,200,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	213,005,013.61	286,907,441.26
51210	Өмнөх үеийн үр дүн	213,005,013.61	213,005,013.61
51220	Тайлант үеийн үр дүн		73,902,427.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>218,205,013.61</u>	<u>292,107,441.26</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	420,629,315.00	581,339,653.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,043,015.00	12,560,850.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,043,015.00	12,560,850.00

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,043,015.00	12,560,850.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,043,015.00	12,560,850.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,586,300.00	568,778,803.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	409,043,300.00	519,931,503.45
131005	Хөрөнгийн санхүүжилт		22,919,203.45
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,043,300.00	497,012,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205,000.00	130,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205,000.00	130,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,338,000.00	48,716,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,338,000.00	48,716,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	406,866,780.92	507,437,225.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406,866,780.92	507,437,225.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	393,163,716.92	506,666,885.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	314,264,653.12	366,237,250.09
210101	Үндсэн цалин	278,586,153.12	313,085,070.00
210102	Нэмэгдэл		43,151,480.09
210104	Урамшуулал	24,823,700.00	10,000,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,021,200.00	51,488,600.00
210201	Тэтгэврийн даатгал	29,965,700.00	35,012,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,154,300.00	4,119,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,523,400.00	3,295,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	630,900.00	823,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,746,900.00	8,238,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,464,229.59	12,579,410.00
210301	Гэрэл, цахилгаан	537,000.00	537,360.00
210302	Түлш, халаалт	9,927,229.59	12,042,050.00
2105	Нормативт зардал	118,263,125.00	57,209,616.99
210502	Хоол, хүнс	117,448,825.00	57,209,616.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	50,000.00	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	393,250.00	1,255,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,255,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,055,169.20	17,747,008.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,183,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,593,750.00	1,340,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,461,419.20	10,223,008.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,703,064.00	770,340.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,703,064.00	770,340.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,703,064.00	770,340.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,762,534.08	73,902,427.65
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,762,534.08	73,902,427.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>418,586,300.00</u>	<u>545,859,600.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,586,300.00	545,859,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	409,043,300.00	497,012,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,043,300.00	497,012,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205,000.00	130,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205,000.00	130,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,338,000.00	48,716,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,338,000.00	48,716,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>415,641,200.00</u>	<u>504,235,681.09</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,641,200.00	504,235,681.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	401,938,136.00	503,465,341.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,428,500.00	366,187,250.09
210101	Үндсэн цалин	278,311,700.00	313,085,070.00
210102	Нэмэгдэл		43,101,480.09
210104	Урамшуулал	24,823,700.00	10,000,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,582,900.00	51,488,600.00
210201	Тэтгэврийн даатгал	29,965,700.00	35,012,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,154,300.00	4,119,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,523,400.00	3,295,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	630,900.00	823,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,308,600.00	8,238,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,288,000.00	12,615,960.00
210301	Гэрэл, цахилгаан	787,000.00	647,360.00
210302	Түлш, халаалт	8,501,000.00	11,968,600.00
2105	Нормативт зардал	13,862,436.00	60,332,931.00
210502	Хоол, хүнс	13,047,736.00	60,332,931.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,050,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	50,000.00	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	417,400.00	1,255,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,255,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,114,000.00	11,435,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,935,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,114,000.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,703,064.00	770,340.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,703,064.00	770,340.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,703,064.00	770,340.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,945,100.00</u>	<u>41,623,918.91</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	41,623,918.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгэ эний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,200,000.00	-	213,005,013.61		218,205,013.61
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,200,000.00	-	213,005,013.61	-	218,205,013.61
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,200,000.00	-	213,005,013.61	-	218,205,013.61
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,200,000.00	-	213,005,013.61	-	218,205,013.61
D08	Тайлант үеийн үр дүн			73,902,427.65		73,902,427.65
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,200,000.00	-	286,907,441.26	-	292,107,441.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	545,729,100.00	503,465,341.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	545,729,100.00	503,465,341.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545,729,100.00	503,465,341.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,622,200.00	366,187,250.09
210101	Үндсэн цалин	332,100,700.00	313,085,070.00
210102	Нэмэгдэл	64,520,800.00	43,101,480.09
210104	Урамшуулал	10,000,700.00	10,000,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,488,600.00	51,488,600.00
210201	Тэтгэврийн даатгал	35,012,400.00	35,012,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,119,100.00	4,119,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,295,200.00	3,295,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	823,800.00	823,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,238,100.00	8,238,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,255,600.00	12,615,960.00
210301	Гэрэл, цахилгаан	1,287,000.00	647,360.00
210302	Түлш, халаалт	11,968,600.00	11,968,600.00
2105	Нормативт зардал	60,619,100.00	60,332,931.00
210502	Хоол, хүнс	60,619,100.00	60,332,931.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	150,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	150,000.00	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,258,000.00	1,255,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,258,000.00	1,255,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,335,600.00	11,435,600.00

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,835,600.00	9,935,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	545,729,100.00	545,089,260.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	497,012,300.00	497,012,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	497,012,300.00	497,012,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,716,800.00	48,076,960.00
132001	Орон нутгийн төсвөөс	48,716,800.00	48,076,960.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		41,623,918.91
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37.00	37.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	15.00	15.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37.00	37.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	21.00	21.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсөв 130.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байсан.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	130,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	130,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	130,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	130,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	130,500.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		130,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	130,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	130,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		130,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус цэцэрлэг нь 2022 онд “Хүүхдийн нас сэтгэл зүйн онцлогт тохируулан багш, ажилчид, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоогоор хүүхдэд “ЭЭЛТЭЙ СУРГАЛТЫН

ОРЧИН” бүрдүүлж, тэдний хүсэл сонирхолыг эрхэмлэн тоглонгоо хөгжүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд суурилан багшийн болон сургуулийн төлөвлөгөөг чанартай боловсруулж, гүйцэтгэлд суурилсан үнэлгээг цэцэрлэгт нэвтрүүлэх
- Багш бүр бүлгээр, багаар хамтран ажиллах нөхцлийг цэцэрлэг бүр “мэргэжлийн баг” үүсгэж ажиллах.
- Хүүхэд эрүүл бие, бялдартай, биеийн хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд идэвхи сонирхолтой оролцож, болзошгүй осол гэмтлээс сэргийлэх, эрүүл амьдрах дадалтай болох.
- Хүүхэд өөрийн болон хүмүүсийн сэтгэл хөдлөл, зан байдлыг танин мэдэх, ойлгох, сэтгэлийн хөдөлгөөн, зан, үйл, харилцаагаа эерэгээр зохицуулах хүмүүстэй хүндэтгэлтэй харилцах.
- Хүүхэд өөртөө итгэлтэй, эерэг зан чанартай, тууштай, суралцах сонирхолтой байх.
- Хүүхэд хүмүүсийг сонсож, тэдэнтэй ярилцаж мэдээлэл солилцох дуртай, санаа бодол, мэдрэмж, мэдлэг төсөөллөө хэл яриагаар илэрхийлэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт тэгш хамруулан сургах, хамрагдалтыг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэг нь Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн захирлын 2022 оны 01 дугаар сарын 01-ны өдрийн А-11 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 73.9 сая төгрөгөөр буюу 25.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	41.623.9	41.623.9
Авлага	15.000.0	-	-
Бараа материал	15.212.1	34.594.4	19.382.3
Үндсэн хөрөнгө	187.992.8	215.889.0	27.896.2
Нийт хөрөнгө	218.205.0	292.107.4	73.902.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	218.205.0	292.107.4	73.902.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	218.205.0	292.107.4	73.902.4

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 41.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь батлагдсан төсвөөс үндсэн цалингийн зардал хэмнэснээс үүдэлтэй бөгөөд үндсэн цалингийн хэмнэлтээс 19.0 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 45.6 хувийг, нэмэгдэл цалингийн

зардлаас 21.4 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 51.4 хувийг, бараа үйлчилгээний бусад зардлаас 0.9 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 2.1 хувийг эзэлж байна.

Авлага нь оны эхэнд 15.0 сая төгрөгийн авлагатай байсныг барагдуулж, оны эцэст авлага үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс 27.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 15.2 сая, бусад эх үүсвэрээс 22.9 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 10.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 546.0 сая, орон нутгийн төсвөөс 48.7 сая, нийт зарлагыг 594.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 48.9 сая төгрөгөөр бууруулж 545.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарлалтад өөрчлөлт орсон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 497.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 48.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нэмэлт санхүүжилт 0.1 сая төгрөгийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 497.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 48.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 06 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 503.5 сая төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлын төсвийг 19.0 сая төгрөгөөр, нэмэгдэл цалингийн зардлын төсвийг 21.4 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлаас 0.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ төгрөгөөр/

Д / Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	1,258,000.00	1,255,000.00	3,000.00	99.76
2	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	6,780,000.00	6,780,000.00	-	100.00
3	Эрүүл мэндийн арга хэмжээ	1,700,000.00	1,700,000.00	-	100.00

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Боловсролын арга хэмжээ	406,622,200.00	366,187,250.09	40,434,949.91	90.06
5	Үдийн цай хөтөлбөр	60,619,100.00	60,332,931.00	286,169.00	99.53
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4,005,600.00	3,105,600.00	900,000.00	77.53
7	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	13,255,600.00	12,615,960.00	639,640.00	95.17
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	51,488,600.00	51,488,600.00	-	100.00
	Дүн	545,729,100.00	503,465,341.09	42,263,758.91	95.26

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дэлүүн сумын 2 дүгээр цэцэрлэг 2022 онд нэмэлт төсөв 0.1 сая төгрөг авч зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Дэлүүн сумын 2 дүгээр цэцэрлэг нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Ц.Оюунтуул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А-02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 406.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 % байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгт завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 118.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 1.4 сая төгрөгийн 1 акт, 4.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,356.8	1	1,356.8	100%
Албан шаардлага	2	118,260.6	2	118,260.6	100%
Зөвлөмж	1	4,850.8	1	4,850.8	100%
Нийт дүн	4	124.468.2	4	124.468.2	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ байгууллагын онцлогт тохируулан батлах, хүнсний технологийн картыг баталж хэрэгжүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт 0.7 сая төгрөгөөр алдаатай тайлагнасныг залруулга хийсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт төсвийн 0.1 сая төгрөгийг оруулж тайлагнасан, Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт Орон нутгийн төсвийн санхүүжилтээс 0.6 сая төгрөгийн төвлөрүүлэг шилжүүлгийг цэвэрлээгүй тайлагнаж ирүүлснийг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэр болон зарлагаас хасаж цэвэрлэж залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Цэцэрлэгийн эрхлэгч нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10/9 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт" -ийн дагуу эрхлэгчийн ур чадварыг үнэлж дүгнээгүй байхад Сумын Засаг даргын 2021 оны А/48 дугаар захирамжийг үндэслэн 1.673.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл авсныг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн байх	1	130.0					1	130.0				
Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн байх	1	639.8					1	639.8				
	2	769.8					2	769.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шалгуур үзүүлэлт хангаагүй ур чадварын нэмэгдэл авсан	1	1.673.5	1	1.673.5								
Дүн	1	1.673.5	1	1.673.5								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит
